



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯНХУТАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 8/30

Баянхутаг сум

**ОЙ ХЭЭРИЙН ТҮЙМРЭЭС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ, АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТУХАЙ**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Засгийн газрын 2013 оны 106 дугаар тогтоолын журам, Улсын онцгой комиссын 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн "Ой хээрийн гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай" 01 дүгээр албан даалгаварыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баянхутаг сум ой хээрийн гал түймэр гарах эрсдэл өндөртэй сумдын тоонд орсон тул, Гамшгаас хамгаалах тухай, Ойн тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангуулан, ой хээрийн гал түймэр унтраах техник багаж хэрэгслийн нөөц бэлтгэл бэлэн байдлыг ханган ажиллахыг Засаг даргын тамгын газрын дарга /Г.Болд/, Байгаль орчны улсын байцаагч /Л.Энхцэцэг/-т даалгасугай.

2. Ой хээрийн гал түймэр гарсан тохиолдолд, эзэн холбогдогчыг тогтоох, ой хээрийн гал түймэртэй тэмцэх чиглэлээр хамран ажиллахыг сумын хэсгийн төлөөлөгч /Б.Заяабаатар/-т үүрэг болгосугай.

3. Хуурайшилтын зэрэг цаг агаарын төлөв байдал, ус цаг уур орчны судалгаа, Онцгой байдлын газар болон Байгаль орчин аялал жуулчлалын газрын мэдээллээр хангах, иргэдэд хавар намрын хуурайшилтын мэдээг цахим орчинд хүргэхийг Холбоо зарлан мэдээлэл хариуцсан ажилтан /Д.Норов-Эрдэнэ/-д даалгасугай.

4. Ой хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа, түймэр унтраах хөдөлмөрийн аюулгүй байдлыг бүрэн хангуулах, эрүүл ахуйн тухай хууль бусад холбогдох дүрэм журмыг тогтмол сурталчилж зааварчилгаа өгч ажиллахыг Сургалт сурталчилгаа хариуцсан ажилтан /М.Оюундарь/-д үүрэг болгосугай.

5. Ой хээрийн гал түймэр унтраах ажиллагаанд оролцож буй алба хаагчдын аюулгүй байдалыг хангуулж, зааварчилгааг тогтмол өгч удирдлагаар хангаж ажиллахыг сумын шуурхай штабын дарга /Г.Болд/-д даалгасугай.

6. Ой хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, авран хамгаалах унтраах ажлыг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангах, хяналтыг хэрэгжүүлэх ажлыг мэргэжлийн ангийн дарга /С.Наранбадрал/-д үүрэг болгосугай.

7. Аймгийн засаг даргын 01 дүгээр албан даалгавар хэрэгжилтийг хангуулж удирдлага зохион байгуулалтаар хангаж, төлөвлөгөө гаргаж ажиллахыг Засаг даргын тамгын газрын дарга, Шуурхай штабын дарга /Г.Болд/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Д.БАЙТАЛМАА



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Засаг дарга

Шуурхай штабын дарга

Хүснэгт 2